

ХААН СОЁМБО АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/36/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2023 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Гүйцэтгэсэн чанарын хяналт, ахлах аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗГСУМС	Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн систем

АГУУЛГА

1. АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.5.1 Төсвийн төлөвлөлт	16
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	16
3.6.3 Нэмэлт төсөв.....	16
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Албан шаардлага	18
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/118
танай _____ -ны № _____ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Л.ЮМЖИРДУЛАМ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд мөнгөн хөрөнгийн данс 11.7 сая төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Аудитаар нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 8.0 сая төгрөгийн залруулга хийж, тайлант онд үүссэн 0,5 сая төгрөгийн өр төлбөртэй холбоотой асуудалд зөвлөмж хүргүүлж ажилласан.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь 2022 онд 1 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас 99.9 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,804,889,503.24	16,256,016,463.50
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	8,666,864,458.83	11,673,352,629.15
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.00	0.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	8,645,066,458.83	11,673,352,629.15
31210	Төгрөг	8,645,066,458.83	11,673,352,629.15
31211	Төрийн сангийн харилцах	9,829.99	0.00
31212	Монгол банкинд дахь харилцах	0.00	0.00
31213	Арилжааны банк дахь харилцах	8,645,056,628.84	11,673,342,799.16
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	0.00	9,829.99
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	0.00	0.00
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	21,798,000.00	0.00
32120	Гадаад валют	0.00	0.00
33	АВЛАГА	6,120,366,149.17	4,566,748,154.11
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0.00	0.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	691,981,733.26	1,006,192,961.19
33300	Татаас, санхүүжилтийн авлага	4,978,618,406.61	3,276,571,954.61
33400	Зээлийн хүүгийн авлага	0.00	0.00
33500	Бусад авлага	449,766,009.30	283,983,238.31
33510	Байгууллагаас авах авлага	449,766,009.30	283,983,238.31
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	17,658,895.24	15,915,680.24
35100	Түүхий эд материал	0.00	0.00
35400	Хангамжийн материал	17,658,895.24	15,915,680.24
35410	Бичиг хэргийн материал	2,175,400.00	57,470.00
35420	Аж ахуйн материал	13,105,946.00	13,212,146.00
35430	Сэлбэг хэрэгсэл	503,600.00	983,380.00
35440	Түлш, шатах тослох материал	157,000.00	129,100.00
35450	Барилгын засварын материал	0.00	89,200.00
35460	Хүнсний материал	0.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	1,716,949.24	1,444,384.24
35500	Биологийн хөрөнгө	0.00	0.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	547,507,129.65	588,903,206.48
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	0.00	0.00
37330	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	547,507,129.65	588,903,206.48
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	493,171,303.79	538,153,787.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	408,841,777.01	408,841,777.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,451,962.91	-38,639,503.97
39203	Авто-тээврийн хэрэгсэл	20,970,000.00	20,970,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.00	-3,495,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	117,583,247.38	174,248,326.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-54,318,526.61	-45,531,353.36
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	67,420,700.00	65,720,700.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-39,873,931.08	-43,961,158.32
39217	Ном	0.00	0.00
39300	Биет бус хөрөнгө	54,335,825.86	50,749,418.74
39301	Програм хангамж	4,585,632.00	4,585,632.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-249,806.14	-3,836,213.26

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

39303	Бусад биет бус хөрөнгө	50,000,000.00	50,000,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	0.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	15,352,396,632.89	16,844,919,669.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	630,851,898.92	238,191,232.28
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	630,851,898.92	238,191,232.28
41100	Богино хугацаат үнэт цаас	0.00	0.00
41300	Өглөг	295,250,580.33	76,017,092.70
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	295,250,580.33	76,017,092.70
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	0.00	0.00
41400	Урьдчилж орсон орлого	335,601,318.59	162,174,139.58
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	335,601,318.59	162,174,139.58
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	0.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	14,721,544,733.97	16,606,728,437.70
51	Засгийн газрын хувь оролцоо	14,721,544,733.97	16,606,728,437.70
51100	Засгийн газрын оруулсан капитал	287,579,968.77	287,579,968.77
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	287,579,968.77	287,579,968.77
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0.00	0.00
51200	Хуримтлагдсан үр дүн	14,323,217,547.43	16,208,401,251.16
51210	Өмнөх үеийн үр дүн	14,126,406,954.33	14,318,194,064.67
51220	Тайлант үеийн үр дүн	196,810,593.10	1,890,207,186.49
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110,747,217.77	110,747,217.77
52	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	15,352,396,632.89	16,844,919,669.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	163,626,981,903.94	147,397,778,519.21
11	ТАТВАРЫН ОРЛОГО	41,264,363,437.24	40,592,712,405.47
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	41,264,363,437.24	40,592,712,405.47
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,693,348,164.85	28,333,523,060.20
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,559,794,474.20	2,934,379,893.17
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,526,456,802.12	1,754,860,219.11
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	471,792,716.29	545,987,114.01
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,012,971,279.78	7,023,962,118.98
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	501,296,844.49	176,554,995.74
120	Нийтлэг татварын бус орлого	501,296,844.49	176,554,995.74
120002	Хүүгийн орлого	19,531,063.53	1,485,686.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,342,489.96	3,898,955.60
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,532,389.96	3,734,955.60
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	810,100.00	164,000.00
120009	Бусад орлого	439,039,959.00	160,386,754.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	35,383,332.00	10,783,600.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	121,861,321,622.21	106,628,511,118.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	16,900,928,448.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	16,900,928,448.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00	19,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	19,200,000.00
1330	Төсвийн захирагчдаас	120,966,123,422.21	88,817,993,370.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,966,123,422.21	88,817,993,370.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	894,913,200.00	890,389,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	894,913,200.00	882,056,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	8,332,400.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	163,430,171,310.84	145,507,571,332.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,430,171,310.84	145,507,571,332.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	902,614,116.02	909,894,255.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,365,282.00	678,061,190.19
210101	Үндсэн цалин	460,362,409.00	473,309,905.57
210102	Нэмэгдэл	130,494,873.00	105,009,446.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,708,000.00	27,905,793.56
210104	Урамшуулал	10,800,000.00	71,836,044.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,277,836.05	84,482,420.18
210201	Тэтгэврийн даатгал	56,928,034.75	57,557,016.29
210202	Тэтгэмжийн даатгал	6,335,393.38	6,767,225.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,068,314.70	5,377,791.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,267,078.68	1,334,138.25
210205	Эрүүл мэндийн даатгал	12,679,014.54	13,446,249.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,235,263.17	25,840,875.51
210301	Гэрэл, цахилгаан	3,232,581.88	3,377,136.03
210302	Түлш, халаалт	18,986,300.00	18,986,353.80
210303	Цэвэр, бохир ус	3,016,381.29	3,477,385.68
2104	Хангамж, бараа материалын зардал	29,021,790.98	25,123,476.68
210401	Бичиг хэрэг	6,203,850.00	6,171,230.00
210402	Тээвэр, шатахуун	14,641,650.00	13,878,096.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,314,640.98	2,785,850.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	19,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,801,650.00	2,268,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,733,000.00	19,785,723.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	233,000.00	925,000.00
210604	Урсгал засвар	9,500,000.00	18,860,723.00
2107	Томилолт, зочны зардал	2,542,900.00	2,996,500.00
210702	Дотоод албан томилолт	2,542,900.00	2,996,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	81,781,579.28	26,696,567.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,624,334.28	7,708,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,582.00	80,482.00
210807	Газрын төлбөр	4,000.00	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,102,710.00	11,464,730.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,093,953.00	3,642,655.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	50,656,464.54	46,907,503.17
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,983,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	48,656,464.54	44,924,203.17
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,527,557,194.82	144,597,677,076.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,429,896,364.00	130,415,190,724.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	96,396,703,424.00	130,373,022,724.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,016,160.00	10,788,100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,176,780.00	31,379,900.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,097,660,830.82	14,182,486,352.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,097,660,830.82	14,182,486,352.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	196,810,593.10	1,890,207,186.49
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	196,810,593.10	1,890,207,186.49

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн / төгрөгөөр /
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,579,968.77	110,747,217.77	14,126,995,209.02	14,525,322,395.56
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-588,254.69	-588,254.69
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,579,968.77	110,747,217.77	14,126,406,954.33	14,524,734,140.87
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	196,810,593.10	196,810,593.10
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	287,579,968.77	110,747,217.77	14,323,217,547.43	14,721,544,733.97
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	287,579,968.77	110,747,217.77	14,323,217,547.43	14,721,544,733.97
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-5,023,482.76	-5,023,482.76
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	287,579,968.77	110,747,217.77	14,318,194,064.67	14,716,521,251.21
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,890,207,186.49	1,890,207,186.49
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	287,579,968.77	110,747,217.77	16,208,401,251.16	16,606,728,437.70

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	162,547,876,911.33	148,871,172,742.48
11	ТАТВАРЫН ОРЛОГО	40,379,018,195.14	40,179,365,701.76
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	40,379,018,195.14	40,179,365,701.76
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	30,333,717,517.16	28,036,176,309.31
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,303,250,007.82	2,903,573,192.16
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,330,802,571.94	1,735,142,554.23
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	425,906,843.71	539,751,991.69
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	5,985,341,254.51	6,964,721,654.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	259,473,521.98	421,241,040.72
120	Нийтлэг татварын бус орлого	259,473,521.98	421,241,040.72
120002	Хүүгийн орлого	19,531,063.53	1,485,686.14
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	239,942,458.45	419,755,354.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	239,132,358.45	419,591,354.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	810,100.00	164,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	121,909,385,194.21	108,270,566,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	59,394,700.00	18,602,790,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	59,394,700.00	18,602,790,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285,000.00	19,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	19,200,000.00
1330	Төсвийн захирагчдаас	120,954,792,294.21	88,758,186,600.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	120,954,792,294.21	88,758,186,600.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	894,913,200.00	890,389,300.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	894,913,200.00	882,056,900.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	8,332,400.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	163,427,576,965.74	145,864,684,572.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,427,576,965.74	145,864,684,572.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	852,839,296.48	878,431,655.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	621,348,881.00	678,061,190.19
210101	Үндсэн цалин	470,478,979.88	473,309,905.57
210102	Нэмэгдэл	120,085,213.62	105,009,446.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,984,687.50	27,905,793.56
210104	Урамшуулал	10,800,000.00	71,836,044.65
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	82,277,835.05	84,482,420.18
210201	Тэтгэврийн даатгал	56,928,034.07	57,557,016.29
210202	Тэтгэмжийн даатгал	6,335,393.30	6,767,225.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,068,314.64	5,377,791.06
210204	Ажилгүйдлийн даатгал	1,267,078.66	1,334,138.25
210205	Эрүүл мэндийн даатгал	12,679,014.38	13,446,249.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,235,263.17	25,315,783.78

210301	Гэрэл, цахилгаан	3,232,581.88	3,377,136.03
210302	Түлш, халаалт	18,986,300.00	18,461,262.07
210303	Цэвэр, бохир ус	3,016,381.29	3,477,385.68
2104	Хангамж, бараа материалын зардал	29,703,790.98	23,083,846.68
210401	Бичиг хэрэг	7,290,050.00	4,053,300.00
210402	Тээвэр, шатахуун	14,728,200.00	13,850,196.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,314,640.98	2,785,850.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	19,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,310,900.00	2,375,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,500,000.00	39,454,703.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	20,504,780.00
210604	Урсгал засвар	9,500,000.00	18,949,923.00
2107	Томилолт, зочны зардал	2,542,900.00	2,996,500.00
210702	Дотоод албан томилолт	2,542,900.00	2,996,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	80,230,626.28	23,053,912.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	61,624,334.28	7,708,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	2,600,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	82,582.00	80,482.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	154,000.00	0.00
210807	Газрын төлбөр	4,000.00	200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	11,102,710.00	11,464,730.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	5,543,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,983,300.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,983,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,574,737,669.26	144,986,252,916.33
2132	Бусад урсгал шилжүүлэг	96,477,147,038.44	130,803,766,563.34
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	96,296,234,029.32	130,579,350,385.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,016,160.00	10,788,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	147,720,069.12	182,248,178.34
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,176,780.00	31,379,900.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	66,097,590,630.82	14,182,486,352.99
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	66,097,590,630.82	14,182,486,352.99
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-879,700,054.41	3,006,488,170.32
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-879,700,054.41	3,006,488,170.32
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,546,564,513.24	8,666,864,458.83
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,666,864,458.83	11,673,352,629.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	132,553,412,000.00	131,480,750,040.83	-1,072,661,959.17	99.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	132,553,412,000.00	131,480,750,040.83	-1,072,661,959.17	99.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	860,226,600.00	859,231,655.83	-994,944.17	99.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	678,142,400.00	678,061,190.19	-81,209.81	99.99
210101	Үндсэн цалин	475,974,700.00	473,309,905.57	-2,664,794.43	99.44
210102	Нэмэгдэл	103,067,000.00	105,009,446.41	1,942,446.41	101.88
210103	Унаа хоолны хөнгөлөлт	39,177,600.00	27,905,793.56	-11,271,806.44	71.23
210104	Урамшуулал	59,923,100.00	71,836,044.65	11,912,944.65	119.88
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,767,700.00	84,482,420.18	-285,279.82	99.66
210201	Тэтгэврийн даатгал	57,642,100.00	57,557,016.29	-85,083.71	99.85
210202	Тэтгэмжийн даатгал	6,781,400.00	6,767,225.31	-14,174.69	99.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,425,100.00	5,377,791.06	-47,308.94	99.13
210204	Ажилгүйдлийн даатгал	1,356,200.00	1,334,138.25	-22,061.75	98.37
210205	Эрүүл мэндийн даатгал	13,562,900.00	13,446,249.27	-116,650.73	99.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,341,500.00	25,315,783.78	-25,716.22	99.90
210301	Гэрэл, цахилгаан	3,359,600.00	3,377,136.03	17,536.03	100.52
210302	Түлш, халаалт	18,408,000.00	18,461,262.07	53,262.07	100.29
210303	Цэвэр, бохир ус	3,573,900.00	3,477,385.68	-96,514.32	97.30
2104	Хангамж, бараа материалын зардал	23,000,400.00	22,983,846.68	-16,553.32	99.93
210401	Бичиг хэрэг	4,053,300.00	4,053,300.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	13,750,200.00	13,750,196.00	-4.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,536,900.00	2,785,850.68	248,950.68	109.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	285,000.00	19,500.00	-265,500.00	6.84
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,375,000.00	2,375,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,355,400.00	20,354,703.00	-697.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,405,400.00	1,404,780.00	-620.00	99.96
210604	Урсгал засвар	18,950,000.00	18,949,923.00	-77.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,100.00	2,996,500.00	-3,600.00	99.88
210702	Дотоод томилолт албан	3,000,100.00	2,996,500.00	-3,600.00	99.88
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,719,100.00	23,053,912.00	-665,188.00	97.20

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,708,700.00	7,708,700.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,600,000.00	2,600,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,500.00	80,482.00	-18.00	99.98
210807	Газрын төлбөр	200,000.00	200,000.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12,129,900.00	11,464,730.00	-665,170.00	94.52
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	1,983,300.00	83,300.00	104.38
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,983,300.00	83,300.00	104.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	131,693,185,400.00	130,621,518,385.00	-1,071,667,015.00	99.19
2132	Бусад урсгал шилжүүлэг	131,693,185,400.00	130,621,518,385.00	-1,071,667,015.00	99.19
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	131,651,017,400.00	130,579,350,385.00	-1,071,667,015.00	99.19
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	10,788,100.00	10,788,100.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,379,900.00	31,379,900.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	132,553,412,000.00	51,951,507,111.02	-80,601,904,888.98	39.19
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	18,602,790,100.00	18,602,790,100.00	0.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	18,602,790,100.00	18,602,790,100.00	0.00	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	113,950,621,900.00	33,224,462,133.53	-80,726,159,766.47	29.16
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	113,942,289,500.00	33,216,129,733.53	-80,726,159,766.47	29.15
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	8,332,400.00	8,332,400.00	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0.00	124,254,877.49	124,254,877.49	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	124,090,877.49	124,090,877.49	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	164,000.00	164,000.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	8,666,864,458.83	8,666,864,458.83	

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	11,673,352,629.15	11,673,352,629.15	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	105.00	97.00	-8.00	92.38
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52.00	48.00	-4.00	92.31
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	46.00	43.00	-3.00	93.48
620003	Үйлчлэх ажилтан	5.00	4.00	-1.00	80.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	19,200,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	19,200,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	19,200,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	100,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,100,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	19,200,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,200,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,200,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах, сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах чиг үүрэгтэй байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн эрхэм зорилго нь “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах,
- Нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах,
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь олгох

Байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад тайлант онд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.

2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. 2022 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/493 дугаар тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт, бичгийг бүрдүүлэх хянах журам”, 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/72 дугаар тушаалаар баталсан Тэтгэмж тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам”
4. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,492.5 сая төгрөгөөр буюу 9.7 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	8,666.7	11,673.3	3,006.6
Дансны авлага	6,120.4	4,566.7	(1,553.7)
Бараа материал	17.6	15.9	(1.7)
Үндсэн хөрөнгө	547.5	588.9	41.4

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Биет бус хөрөнгө	54.3	50.7	(3.6)
Нийт хөрөнгө	15,352.4	16,844.9	1,492.5
Дансны өглөг	630.8	238.1	(392.7)
Эздийн өмч	287.6	287.6	-
-төрийн	287.6	287.6	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	110.7	110.7	-
Хуримтлагдсан үр дүн	14,323.2	16,208.4	1,885.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,352.4	16,844.9	1,492.5

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өнгөрсөн оноос 3,006.6 сая төгрөгөөр өсөж 11,673.3 сая төгрөг болсон байна.

Тайланд онд дансны авлага 1,553.7 сая төгрөгөөр буурч 4,566.7 сая төгрөг болсон байна. Үүнд: Төлбөртэй үйлчилгээний авлага 1,006.2 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 3,276.6 сая төгрөг, байгууллагаас авах авлага 284.0 сая төгрөг байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд үүссэн авлага дийлэнх хувийг эзэлжээ.

Нийт өр төлбөр 392.7 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс: Бараа үйлчилгээний зардлын өглөг 73.0 сая төгрөг, Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв зардлын өглөг 162.2 сая төгрөг байна.

Бараа материал 1.7 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 41.4 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд:

- Ажлын суурин компьютер 13 ширхэг- 28.8 сая төгрөг
- Зөөврийн компьютер 14 ширхэг – 27.5 сая төгрөг
- Сүлжээний хэвлэгч 1 ширхэг-1.3 сая төгрөг
- Скайнер 1 ширхэг- 2.0 сая төгрөг
- Хувилагч 1 ширхэг – 4.2 сая төгрөг
- Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон нийт 3.3 сая төгрөгийн хөрөнгө
- Тавилга 2.2 сая төгрөг
- Машин тоног төхөөрөмж 1.0 сая төгрөгийн хөрөнгийг тус тус бүртгэсэн байна.

Хүснэгт 2. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Биет хөрөнгө	493.2	538.1	44.9
Барилга, байгууламж, орон сууц	408.8	408.8	0.00
Хуримтлагдсан элэгдэл	-27.4	-38.6	-11.2
Авто-тээврийн хэрэгсэл	21.0	21.0	0.00
Хуримтлагдсан элэгдэл	0.0	-3.5	-3.5
Машин тоног төхөөрөмж (компьютер)	117.6	174.2	56.6
Хуримтлагдсан элэгдэл	-54.3	-45.5	8.8
Тавилга, аж ахуйн эд хогшил	67.4	65.7	-1.7
Хуримтлагдсан элэгдэл	-39.9	-44.0	-4.1
Биет бус хөрөнгө	54.3	50.7	-3.6
Програм хангамж	4.6	4.6	0.00
Хуримтлагдсан элэгдэл	-0.2	-3.8	-3.6
Бусад биет бус хөрөнгө	50.0	50.0	0.00

Хуримтлагдсан үр дүн 1,885.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	287.6	287.6	0.00
Хуримтлагдсан үр дүн	14,323.2	16,208.4	1,885.2

Өмнөх үеийн үр дүн	14,332.4	14,318.2	-14.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	110.7	110.7	0.00

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 143,157.7 сая, нийт зарлагыг 143,157.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 10,604.3 сая төгрөгөөр бууруулж, 132,553.4 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 33,324.5 сая төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 124.2 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 131,480.7 сая төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Хүснэгт 4. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71901	Нийгмийн даатгал	890.4	890.1	0.3	99.9
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	777.3	777.3	0	100.0
80103	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	28.4	28.2	(0.2)	99.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	39.5	39.5	0	100.0
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүд	29.2	29.1	(0.1)	99.0
80205	Мэдээлэл сурталчилгааны зардал	2.7	2.7	0	100.0
80213	Өмгөөлөл хуулийн зөвлөхийн хөлс	2.4	2.4	0	100.0
80813	Хуульд заасан үндэслэлээр алба хаагчдад олгох нэг удаагийн тэтгэмж	2.3	2.3	0	100.0
80820	Бусад тусламж, дэмжлэг	8.5	8.5	0	100.0
	Нийгмийн даатгалын сан	131,663.0	130,590.6	1,072.4	99.1
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	12.0	11.3	(0.7)	94.0
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж	131,651.0	130,579.3	119.4	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт төсвийн дансаар Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлсэн “Малчдын нийгмийн хамгааллыг өргөжүүлж, цочролд хариу үзүүлэх бэлэн байдлыг нэмэгдүүлэх нь” зорилтот санхүүжилтээр 19.2 сая төгрөгийн орлого орж, уг төслийн санхүүжилтээр нийлүүлэгдсэн гурван үйлдэлтэй принтерийг 23 суманд сумдад хуваарилсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын хэтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан Соёмбо Аудит ХХК-ийн чанарын хяналт, ахлах аудитор Н.Бадамханд гүйцэтгэж, хяналтыг анхан шатанд Хаан Соёмбо Аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, дараагийн шатны хяналтыг ахлах аудитор Б.Давааням, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1.5 хувиар буюу 230.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 161.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилот, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 2022 онд мэдээллийг бүрэн оруулж ажилласан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар нийт 3.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 0.3 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 3.1 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмжийн биелэлтийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, нягтлан бодох бүртгэлийн хуультай холбоотой асуудлаар 1 зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	104.8	1	104.8	100
Зөвлөмж	1	-	1	-	100
Нийт дүн	2	104.8	2	104.8	100

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 8.0 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 8.0 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Жолоочийн замын хуудасгүй, тооцоо бодолгүйгээр 1.0 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байсныг залруулсан. Анхан шатны баримтгүйгээр 7.0 сая төгрөгийн гүйлгээ хийсэн, баримт дутуу байсныг залрууллаа. Мөн цалингийн нэмэгдлийг бөөн дүнгээр ойлгомжгүй тэмэгдлэсэн байсныг залруулав.

Аудитаар нийт 0.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 0.5 сая төгрөгийн зөвлөмж өглөө.

5.1 ТӨЛБӨРИЙН АКТ

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

5.2 АЛБАН ШААРДЛАГА

Албан шаардлага өгөөгүй болно.

